



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИНИН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 09-аадар

Дугаар 1/20

Мандалговь

Г Орон нутгийн өмчийн үл хедлэх хөрөнгийг<sup>1</sup>  
дахин үнэлэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 "а". Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын 1 болон 4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны А-1/1694 тоот албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Орон нутгийн өмчийн үл хедлэх хөрөнгийн дахин үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: - Аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Орлогч дарга: - Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: - Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

- Аймгийн Оюуны эмч Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

- Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын санхүүч

- Аймгийн Эрүүл мэндийн газрын санхүүч

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн ерөнхий санхүүч

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө

оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн

эдийн засгийн бодлого төлөвлөлт хариуцсан ерөнхий

эдийн засагч

- Аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргжилтэн

Нарийн бичгийн дарга: - Аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргжилтэн

Хоёр. Орон нутгийн өмчийн үл хедлэх хөрөнгийн дахин үнэлгээ хийх ажлын төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Гурав. Үл хедлэх хөрөнгийн дахин үнэлгээ хийх ажлын хэсгүүдийг бүх сумд, орон нутгийн өмчийт болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагуудад байгуулж, холбогдох хууль, журам заавар, төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг сумын Засаг дарга, орон нутгийн өмчийт болон өмчийн оролцоотой байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

Дөрөв. Орон нутгийн өмчийн газрын төсөвт төсөвлэгдсэн хөрөнгийг зориулалтын дагуу захирал зарцуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга С.Ууганбаяарт үүрэг болгосугай.

Тав. Үл хедлэх хөрөнгийн дахин үнэлгээг хууль тогтоомж, журам заавар, төлөвлөгөөний дагуу батлагдсан төсөвт багтаан зохион байгуулж 2018 оны 07 дугаар сарын 30-ны дотор нэгдсэн дүнг аймгийн Засаг даргын давхарлийн хуралд танилцуулсан, улсын комисст хүлээлгэн өвөхийг ажлын төсогт даалгасугай:

ЗАСАГ ДАРГА ОБАТ-ЭРДЭНЭ

0200068

